



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН ТАНИЛЦУУЛГА



2014 оны 12 дүгээр
сарын 08-ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэ оны эхний 11 сарын байдлааргээмт хэрэг, зөрчлийн статистик дахь гадаадын иргэдтэй холбоотой мэдээний талаар

Нэг: Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэдийн тухай

Манай улсын нутаг дэвсгэрт 2014 оны эхний **11** сарын байдлаар **гадаадын 83 иргэн** гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 10-аар буюу 13.6 хувиар өссөн байна.

Гэмт хэрэгт:

- БНХАУ-ын **33**,
- ОХУ-ын **17**,
- БНСУ-ын **10**,
- Гүрж улсын **6**,
- Вьетнам улсын **6**,
- Бангладеш улсын **2**,
- Казахстан улсын **2**,
- АНУ-ын **2**,
- Итали улсын **1**,
- Румын улсын **1**,
- Турк улсын **1**,
- Унгар улсын **1**,
- Япон улсын **1** иргэн холбогджээ.

Гэмт хэргийн төрлөөр авч үзвэл:

- Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэгт **20**,
- Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах хэрэгт **17**,
- Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэгт **7**,
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэгт **7**,
- Татвар төлөхөөс зайлсхийх хэрэгт **4**,
- Хууль бусаар ашигт малтмал олборлох хэрэгт **4**,
- Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших хэрэгт **3**,
- Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих хэрэгт **3**,
- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах хэрэгт **2**,
- Танхайрах хэрэгт **2**,
- Аюулгүй ажиллагааны журам зөрчих хэрэгт **2**,
- Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах хэрэгт **2**,
- Хүнийг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах, хүн худалдаалах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг завших, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх хэрэгт тус бүр гадаадын **1** иргэн холбогдон шалгагдсан байна.

Нутаг дэвсгэрээр нь авч үзвэл:

- Дорнод аймагт **7**,

- Сэлэнгэ аймагт **5**,
- Дархан-Уул аймагт **4**,
- Орхон аймагт **3**,
- Өмнөговь аймагт **2**,
- Хэнтий аймагт **2**,
- Баян-Өлгий аймагт **1**,
- Завхан аймагт **1**,
- Ховд аймагт **1**,
- Говьсүмбэр аймагт **1**,
- Дорноговь аймагт **1**,
- Төв аймагт **1**,
- Улаанбаатар хотод **54**, үүнээс
- Баянзүрх болон Сүхбаатар дүүрэгт тус бүр **13**
- Чингэлтэй дүүрэгт **9**,
- Баянгол дүүрэгт **8**,
- Хан-Уул дүүрэгт **5**, Сонгинохайрхан болон Налайх дүүрэгт тус бүр **3** иргэн холбогджээ.

Насны ангиллаар авч үзвэл:

- 16-17 насны **3**,
- 18-24 насны **7**,
- 25-29 насны **8**,
- 30-34 насны **8**,
- 35-39 насны **9**,
- 40-44 насны **14**,
- 45-49 насны **12**,
- 50-54 насны **11**,
- 55-59 насны **8**,
- 60-64 насны **3** иргэн байна.

Хоёр: Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэдийн тухай

Манай улсын нутаг дэвсгэрт 2014 оныэхний **11** сарын байдлаар **гадаадын 157 иргэн** гэмт хэргийн халдлагад өртсөн нь өмнөх оны мөн үеийнхээс **37**-аар буюу **30.8** хувиар өссөн байна.

Дээрх иргэдийн:

- **74** нь БНХАУ-ын,
- **33** нь БНСУ-ын,
- **11** нь ОХУ-ын,
- **7** нь Вьетнам улсын,
- **4** нь Франц улсын,
- **3** нь тус бүр АНУ, ХБНГУ, Казахстан, Япон улсын,
- **2** нь тус бүр Австрали, Тайван улсын,
- **1** нь тус бүр Бельги, Украин, Лаос, Чех, Их британи, Нигери, Шинэ Зеланд, Итали, Пакистан, Энэтхэг, Мальдив, Хорват улсын иргэд байна.

Гэмт хэргийн төрлөөр авч үзвэл:

- Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэгт **46**,
- Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах хэрэгт **28**,
- Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэгт **21**,
- Танхайрах хэрэгт **14**,
- Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэгт **13**,
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэгт **10**,
- Хүнийг барьцаалах хэрэгт **4**,
- Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих хэрэгт **4**,
- Алдуул мал, гээгдэл буюу санамсаргүй олдсон эд хөрөнгө завших хэрэгт **4**,

- Бусдын эд хөрөнгө санаатайгаар устгах, гэмтээх хэрэгт **3**,
- Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх хэрэгт **2**,
- Аюулгүй ажиллагааны журам зөрчих хэрэгт **2**,
- Бусдыг амиа хорлоход хүргэх хэрэгт **2**,
- Бусдыг санаатай алах хэрэгт **1**,
- Бусдын эд хөрөнгийг булаах хэрэгт **1**,
- Хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт ашиглах хэрэгт **1**,
- Дураараа аашлах хэрэгт **1** гадаадын иргэн хохирсон байна.

Нутаг дэвсгэрээр нь авч үзвэл:

- Өмнөговь аймагт **12**,
- Хэнтий аймагт **5**,
- Дархан-Уул аймагт **4**,
- Дорнод аймагт **3**,
- Баян-Өлгий, Архангай, Булган, Говьсүмбэр, Дорноговь аймагт тус бүр **2**,
- Орхон, Өвөрхангай аймаг болон Төмөр замын салбарт тус бүр **1**,
- Улаанбаатар хотод **120**, үүнээс:
 - Баянзүрх дүүрэгт **33**,
 - Сүхбаатар дүүрэгт **28**,
 - Баянгол дүүрэгт **21**,
 - Хан-Уул дүүрэгт **19**,
 - Чингэлтэй дүүрэгт **8**,
 - Сонгинохайрхан дүүрэгт **8**,
 - Багануур дүүрэгт **2**,
 - Налайх дүүрэгт **1** гадаадын иргэн гэмт хэргийн халдлагад өртжээ.

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ТӨВ